



**САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ  
2016 ОНЫ 3 ДУГААР УЛИРАЛ**



**Судалгаа, эрсдэлийн шинжилгээ хэлтэс**

## Агуулга

I. Хөрөнгийн зах зээл.....	4
1.1 Хөрөнгийн зах зээлийн хөгжил.....	4
1.2 Хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал.....	4
1.3 Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн арилжаа.....	9
II. Даатгалын зах зээл.....	11
2.1 Даатгалын зах зээлийн хөгжил.....	11
2.2 Даатгалын салбарын бүтэц.....	13
2.3 Даатгалын үйлчилгээний хүртээмж.....	14
2.4 Даатгалын салбарын статистик үзүүлэлтүүд.....	15
III. Хадгаламж, зээлийн хоршоо.....	19
ХЗХ-дын үйлчилгээний хүртээмж.....	19
3.2 ХЗХ-дын салбарын үзүүлэлтүүд.....	20
IV. Банк бус санхүүгийн зах зээл.....	23
4.1 Эдийн засаг дахь гүнзгийрэлт.....	23
4.2 ББСБ-уудын үйлчилгээний хүртээмж.....	23
4.3 ББСБ-уудын тогтвортой байдал.....	25
4.4 ББСБ-ын салбарын үзүүлэлтүүд.....	26
V. Банкнаас бусад санхүүгийн зах зээлийн хураангуй тойм.....	27

Дүрслэл

Дүрслэл 1: Зах зээлийн үнэлгээ, ЗЗҮ/ДНБ .....	4
Дүрслэл 2: ТОП-20 индексийн лаа хэлбэрийн зураг .....	5
Дүрслэл 3: Хувьцааны арилжааны жилийн дүн /тэрбум төгрөг/ .....	6
Дүрслэл 4: Эдийн засгийн өсөлт ба арилжааны бүтэц .....	6
Дүрслэл 5: Арилжааны бүтэц /тэрбум төгрөг/ .....	8
Дүрслэл 6: Банкуудын ипотекийн зээлийн үлдэгдэл 2016 оны 3 дугаар улирал.....	8
Дүрслэл 7: Зээлийн санхүүжилтийн эх үүсвэр болон зээлдэгчид.....	9
Дүрслэл 8: ХААБ-ийн арилжаа .....	10
Дүрслэл 9. Даатгалын гүнзгийрэлтийн түвшин, тэрбум төгрөг .....	11
Дүрслэл 10: Ердийн даатгалын компаниудын зах зээлд эзлэх хувь .....	13
Дүрслэл 11: Даатгалын нягтрал (төгрөг) .....	14
Дүрслэл 12: Даатгалын компани болон зуучлагчдын салбаруудын байршил .....	14
Дүрслэл 13: Даатгалын компани болон зуучлагчдын салбаруудын байршил .....	14
Дүрслэл 14: Нийт хөрөнгө.....	15
Дүрслэл 15: Хураамжийн орлого .....	15
Дүрслэл 16: Нөхөн төлбөр, давхар даатгалын хураамж.....	16
Дүрслэл 17: Цэвэр ашиг .....	17
Дүрслэл 18: Нөөц сангийн хэмжээ, өсөлт.....	17
Дүрслэл 19: Нийт хөрөнгө, өөрийн хөрөнгийн өгөөж.....	18
Дүрслэл 20: Зардлын харьцаа, хохирол нөхөлтийн харьцаа, хосолсон харьцаа.....	18
Дүрслэл 21: ХЗХ-дын тоо, өсөлтийн хувь .....	19
Дүрслэл 22: Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын байршил .....	19
Дүрслэл 24: Хадгаламж, зээлийн хоршоодын нийт хөрөнгийн дүн .....	20
Дүрслэл 25: ХЗХ-дын нийт зээлийн чанар /тэрбум төгрөг/.....	20
Дүрслэл 26: ХЗХ-дын нийт хадгаламж /тэрбум төгрөг/.....	21
Дүрслэл 27: ХЗХ-дын өөрийн хөрөнгө, өр төлбөр /тэрбум төгрөг/ .....	21
Дүрслэл 28: ХЗХ-дын ашигт ажиллагаа /тэрбум төгрөг/.....	22
Дүрслэл 29: Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	22
Дүрслэл 30: Нийт хөрөнгө болон ДНБ-ын харьцаа .....	23
Дүрслэл 31: ББСБ-ын тоо /бүсээр/ .....	23
Дүрслэл 32: ББСБ-ын байршил .....	24
Дүрслэл 33. Зээлдэгчдийн тоо /бүсээр/.....	24
Дүрслэл 34. Зээлдэгчдийн тоо /дүүргээр/.....	24
Дүрслэл 35. Чанаргүй зээлийн хувь .....	25
Дүрслэл 36. ББСБ-ын эрсдэл даах чадвар .....	25
Дүрслэл 37. ББСБ-уудын зах зээлд эзлэх хувь.....	26
Дүрслэл 38. Нийт хөрөнгийн өгөөж.....	27
Дүрслэл 39. Өөрийн хөрөнгийн өгөөж .....	27

Хүснэгт

Хүснэгт 1: Улс орнуудын ЗЗҮ ба ДНБ-ний харьцаа хувиар/2015 он/ .....	4
Хүснэгт 2: Зах зээлийн үнэлгээ хамгийн их 30 компани, улирлын өсөлт /хувиар/.....	5
Хүснэгт 3: ЗГ-ын богино хугацаат жижиглэнгийн үнэт цаасны 3 дугаар улирлын анхдагч зах зээлийн арилжааны мэдээ .....	7
Хүснэгт 4: "ҮЦТХТ" ХХК-д бүртгэлтэй дансны тоо, ангиллаар, 9 дүгээр сарын 31-ний байдлаар .....	7
Хүснэгт 5: ХААБ-ын 3 дугаар улирлын арилжаа .....	9
Хүснэгт 6. Хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хураамжийн орлогын өсөлтийн хувь (2015/2014).....	11
Хүснэгт 7: Даатгалын салбарын мэргэжлийн оролцогчид .....	13
Хүснэгт 8: Салбарын товч мэдээлэл .....	15

## I. Хөрөнгийн зах зээл

### 1.1 Хөрөнгийн зах зээлийн хөгжил

Олон улсын хэмжээнд хөрөнгийн зах зээлийн хөгжлийг ДНБ-д эзлэх нийт зах зээлийн үнэлгээ (ЗЗҮ)-ний хувиар (market capitalization) илэрхийлдэг. 2015 оны жилийн эцэст Дэлхийн банкны тооцоолсноор дэлхийн ДНБ-д эзлэх нийт 57 орны ЗЗҮ 97.8 хувь байсан бол Монгол Улсад 5 хувьтай байна. Дэлхийн банкинд уг мэдээллийг ирүүлсэн 57 орны дотор манай орон доогуур байр эзэлж байна. Харин ЗЗҮ/ДНБ-ны харьцаа 100 хувиас давсан 7 орон байна. Эдгээрт өндөр хөгжилтэй Хонгконг, Канад, Сингапур, Америк, Швейцарь, Малайз, Япон орж байна (**Хүснэгт 1**). Уг үзүүлэлтээр доогуур 8 орны дотор эдийн засгийн шилжилтийн үеийг дөнгөж даван туулаад байгаа орнууд, Латин Америкийн болон Африкийн хөгжил буурай орнууд тус тус орсон байна.

Хүснэгт 1: Улс орнуудын ЗЗҮ ба ДНБ-ний харьцаа хувиар/2015 он/

Д/Д	ЗЗҮ хамгийн өндөр орон	ЗЗҮ/ДНБ харьцаа хувиар	ЗЗҮ хамгийн бага орон	ЗЗҮ/ДНБ харьцаа хувиар
1	Хонгконг	1027.6%	Монгол	5%
2	Швейцарь	228.5%	Аргентин	9.6%
3	Сингапур	218.6	Нигер	10.3%
4	Америк	139.6	Кибер	13.9%
5	Малайз	129.2	Слован	14.1%
6	Япон	118.7	Унгар	14.6%
7	Канад	102.7	Египет	16.6%
8	Нидерланд	96.8%	Казакстан	18.9%


Эх үүсвэр: Дэлхийн банк

2011 онд уг үзүүлэлт 16 хувьд хүрч байсан нь эдийн засгийн өсөлт, гадаадын шууд хөрөнгө оруулалт зэрэг макро эдийн засгийн таатай нөхцөл байдал нөлөөлсөн юм. 2016 он гарснаас хойш макро эдийн засгийн удаашрал, санхүүгийн зах зээлийн зогсонги байдал зэргээс үүдэн энэ жилийн эцэст 5 хувиас доогуур түвшинд гарахаар хүлээгдэж байна.

### 1.2 Хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн бүртгэлд 2016 оны 3 дугаар улирлын байдлаар 228 хувьцаат компани бүртгэлтэй байгаа бөгөөд нийт зах зээлийн үнэлгээ (ЗЗҮ) өмнөх оны мөн үеэс 7.5 хувиар буюу 97.8 тэрбум төгрөгөөр өсч, жилийн эхнээс 10 хувиар буюу 127.7 тэрбум төгрөгөөр өсч, өмнөх улирлаас 2.49 хувиар буюу 35.4 тэрбум төгрөгөөр буурч 1.38 их наяд төгрөг болсон байна (**Дүрслэл 1**).

Дүрслэл 1: Зах зээлийн үнэлгээ, ЗЗҮ/ДНБ



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хороо

3 дугаар улирлын ДНБ-д эзлэх нийт ЗЗҮ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.5 функтээр нэмэгдэж 8 хувьд хүрсэн байна. Гэвч энэ нь 2011 онтой харьцуулахад 2.5 дахин бага үзүүлэлт юм.

2016 оны 3 дугаар улирлын байдлаар хүснэгт 3-д үзүүлсэн 30 компанийн ЗЗҮ нийт ЗЗҮ-ний 89.2 хувь буюу 1.24 их наяд төгрөгийг бүрдүүлж байна. Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 30 компанийн хувьцааны арилжаанд “Техник импорт” ХК-ийн ЗЗҮ 90 хувиар буюу 3.6 тэрбум төгрөгөөр өсч, хамгийн сайн үзүүлэлттэй байсан бол эсрэгээр “Шарын гол” ХК-ийн хувьцаа 32.4 хувиар буурч хангалтгүй үзүүлэлттэй байлаа.

Хүснэгт 2: Зах зээлийн үнэлгээ хамгийн их 30 компани, улирлын өсөлт /хувиар/


№	Хувьцааны нэр	ЗЗҮ /тэрбум төгрөг/	3 дугаар улирлын өсөлт бууралт	№	Хувьцааны нэр	ЗЗҮ /тэрбум төгрөг/	3 дугаар улирлын өсөлт бууралт
1	АПУ	295.5	-8.8%	16	ТАЛХ ЧИХЭР	20.1	5.4%
2	МИК ХОЛДИНГ	217.4	-17.6%	17	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	17.7	-9.1%
3	ТАВАН ТОЛГОЙ	101.0	34.1%	18	БАЯНГОЛ ЗБ	16.1	-1.2%
4	ГОВЬ	76.0	16.8%	19	МОН.ЦАХИЛГААН ХОЛБОО	15.8	-22.8%
5	БАГАНУУР	63.6	-16.2%	20	БЭРХ УУЛ	15.3	-10.6%
6	СҮҮ	47.0	-8.9%	21	ХАЙ БИ ОЙЛ	12.9	-23.8%
7	УБ БУК	39.5	-11.6%	22	МАТЕРИАЛИМПЕКС	12.6	2.5%
8	ШИВЭЭ ОВОО	35.3	-1.0%	23	АТАР ӨРГӨӨ	10.8	0.0%
9	МОНГОЛ ШУУДАН ХК	28.8	-3.2%	24	ГЕРМЕС ЦЕНТР	10.6	3.8%
10	БИДИСЕК	28.6	-8.2%	25	СИЛИКАТ	10.4	0.0%
11	ГУТАЛ	27.4	2.4%	26	МАХ ИМПЕКС	10.3	3.8%
12	МОНГОЛ СЕКЬЮРИТИЕС	26.7	0.2%	27	ТЕХНИК ИМПОРТ	7.7	90.4%
13	ТАХЬ КО	26.0	14.9%	28	АРИГ ГАЛ	7.7	4.8%
14	ШАРЫН ГОЛ	25.9	-32.4%	29	ЖЕНКО ТУР БЮРО	6.5	-7.1%
15	ДАРХАН НЭХИЙ	22.11	13.7%	30	МОНГОЛ ШИЛТГЭЭН	6.4	-1.5%

Эх үүсвэр: “Монголын хөрөнгийн бирж” ХХК

### Хөрөнгийн зах зээлийн индекс

Монголын хөрөнгийн зах зээлийн ерөнхий нөхцөл байдлыг харуулдаг MSE-ALL индекс<sup>1</sup> жилийн эхнээс 40 нэгжээр, өмнөх улирлаас 10 нэгжээр буурч 825.77 нэгж болсон бол ТОП 20 индекс жилийн эхнээс 618 нэгжээр буурч, өмнөх улирлаас 87 нэгжээр өсч 11,539 нэгжид хүрэв (Дүрслэл 2).

Дүрслэл 2: ТОП-20 индексийн лаа хэлбэрийн зураг



Эх үүсвэр: “Монголын хөрөнгийн бирж” ХХК

Тайлбар: Лаан зураг(candlestick)-ын хар нь тухайн хувьсагчийн уналтыг, цагаан нь өсөлтийг илэрхийлнэ. Тухайн лааны дээд, доод шугам нь нээлт, хаалтын утгыг илэрхийлэх бол лааны орой хэсэг нь тухайн хугацааны


<sup>1</sup>Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй бүх хувьцаагаар тооцдог, ерөнхий индекс. 2015 оны 2 дугаар сараас эхлэн тооцож байгаа бөгөөд анхны утга нь 1000 нэгж.

интервалын хамгийн их болоод хамгийн бага утгыг илэрхийлдэг. Лаа хэдий богино байх тусам нээлт хаалтын утга хэр ойрхон байсныг, лааны орой хэр урт байх нь тухайн хугацааны интервалд хэр зэрэг хэлбэлзэлтэй байсныг илэрхийлдэг.

### Хувьцааны арилжаа

2016 оны 3 дугаар улиралд “Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй 58 брокер, дилерийн компаниуд 6.3 сая ширхэг хувьцааг 32.5 тэрбум төгрөгөөр арилжаалсан байна. Үүнд: Нийт арилжааны 87 хувь нь “Ти Ди Би Капитал” ХХК, 8.6 хувь нь “БиДиСек” ХК-аар дамжин арилжигдсан бол үлдсэн 3.9 хувь нь бусад брокер, дилерийн компаниар дамжин арилжаалагдсан байна (Дүрслэл 3).

Дүрслэл 3: Хувьцааны арилжааны жилийн дүн /тэрбум төгрөг/




Эх үүсвэр: Монголын хөрөнгийн бирж

Эдийн засгийн өсөлт саарч, санхүүгийн тогтвортой байдал сайнгүй байгаа энэ үед хувьцааны арилжааны дүн 2016 оны 3 дугаар улирлын гүйцэтгэлээр 45.8 тэрбум төгрөгт хүрээд байгаа нь энэ оны эцэст өмнөх 2 жилийн эцсийн дүнтэй харьцуулахад их гарахаар байна. Хувьцааны жилийн арилжааны дүн өсөх хандлагатай байна.

2014 он гарснаас хойш эдийн засгийн өсөлт саарч хөрөнгийн биржээр хийгдэх арилжааны 60 гаруй хувийг ЗГ-ын бондын арилжаа эзлэх болсон байна (Дүрслэл 4). Засгийн газрын бонд нь эргэн төлөгдөх магадлал хамгийн өндөр, найдвартай санхүүгийн хэрэгсэл юм. Санхүүгийн зах зээлийн удаашрал, тодорхой бус байдлаас үүдэн хөрөнгө оруулагч нар эрсдэл багатай хөрөнгөд хөрөнгө оруулалт хийх хандлага ажиглагдаж байна.

Дүрслэл 4: Эдийн засгийн өсөлт ба арилжааны бүтэц



Эх үүсвэр: “Монголын хөрөнгийн бирж” ХХК

**Засгийн газрын үнэт цаасны арилжаа**

2016 оны 4 дүгээр сарын 25-ны өдрөөс хойш ЗГ-ын жижиглэнгийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг зарлаагүй байсан бөгөөд 3 дугаар улирлын төгсгөлд 9 дүгээр сарын 20, 27-ны өдрүүдэд богино хугацаат 3, 6, 9, 12 сарын хугацаатай үнэт цаасны арилжааг зарлаж 22.69 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн байна(хүснэгт 3).

Хүснэгт 3: ЗГ-ын богино хугацаат жижиглэнгийн үнэт цаасны 3 дугаар улирлын анхдагч зах зээлийн арилжааны мэдээ

д/д	Хугацаа /7 хоног/	Зарласан хэмжээ	Ирсэн саналын хэмжээ	Биелсэн тоо	Биелсэн дүн /тэрбум төгрөг/	Жигнэсэн дундаж хүү	Эзлэх хувь	Биелсэн хувь	ҮЦ-ны дуусах хугацаа
1	12	50,000	74,392	50,000	4.83	15.70%	21.27%	100.0%	2016.12.13
2	28	100,000	135,636	100,000	9.19	16.40%	40.5%	100.0%	2017.04.04
3	39	50,000	64,818	50,000	4.44	16.964%	19.5%	100.0%	2017.06.27
4	52	50,000	49,580	49,580	4.24	17.00%	18.68%	99.2%	2017.09.26
<b>Нийт</b>		250,000	324,426	249,580	22.69		100%	-	-

Эх үүсвэр: Сангийн яам

ЗГ-ын 12 болон 28 долоо хоногтой жижиглэнгийн үнэт цаасыг худалдаж авах ирүүлсэн саналын хэмжээ зарласан хэмжээнээс 40 гаруй хувиар их байгаа нь эрэлт их байгааг харуулж байна. 52 долоо хоногийн хугацаатай үнэт цаасны хувьд эрэлт нь нийлүүлэлтээс бага буюу ирүүлсэн саналын хэмжээ нь зарласан хэмжээнээс бага байна. Хөрөнгө оруулагчид богино хугацаатай, хөрвөх чадвар өндөртэй санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх сонирхол их байна.

**ЗГ-ын үнэт цаасны хоёрдагч зах зээлийн арилжаа:** 2016 оны 1 дүгээр улиралд 2.6 тэрбум төгрөг, 2 дугаар улиралд 1.3 тэрбум төгрөг байсан бол 3 дугаар улиралд нийт 27,704 ширхэг үнэт цаасыг 2.6 тэрбум төгрөгөөр худалдаалсан байна. Анхдагч зах зээлийн үнийн дүнгийн 10 орчим хувийг эзэлж байна.

**Компанийн бондын анхдагч болон хоёрдагч зах зээлийн арилжаа:** 3 дугаар улиралд хийгдээгүй байна. 2016 оны 9 дүгээр сарын байдлаар арилжааны банкуудын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 13.2 хувь буюу өндөр байгаа нь компанийн бондын зах зээл хөгжихгүй байгаагийн нэг шалтгаан байж болох юм.

**Данс эзэмшигчдийн мэдээлэл**

“ҮЦТХТ”<sup>2</sup> ХХК-д 2016 оны 9 дүгээр сарын 31-ний байдлаар нийт 883,444 данс, 136,823 ширхэг холболтын данс бүртгэлтэй байна. 3 дугаар улиралд дансны тоо 2.08 хувиар буюу 18,004-өөр нэмэгдсэн байна. Үүнд: 17,965 нь дотоодын иргэн, 28 нь гадаадын иргэн, 10 нь дотоодын ААН, 1 нь гадаадын иргэн байна.

Хүснэгт 4: "ҮЦТХТ" ХХК-д бүртгэлтэй дансны тоо, ангиллаар, 9 дүгээр сарын 31-ний байдлаар

д/д	Данс эзэмшигчид	Дансны тоо
1	Дотоодын иргэн	878,836
2	Гадаадын иргэн	1,915
3	Дотоодын ААН	2,515
4	Гадаадын ААН	178
<b>Нийт</b>		883,444

Эх үүсвэр: "ҮЦТХТ" ХХК


<sup>2</sup>“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК




**Данс эзэмшигчдийн гүйлгээний дүн ба арилжааны бүтэц**

Үнэт цаасны зах зээлд оролцогч гадаадын ААН, иргэдийн арилжааны дүн 2012 оны 4 дүгээр улирлаас хойш эрс буурч, улиралд дунджаар 1.8 тэрбум төгрөгийн арилжаа хийдэг болсон бол эсрэгээр дотоодын ААН, иргэдийн арилжаа 2014 оны 4 дүгээр улирлаас хойш сэргэж, улиралд дунджаар 60 орчим тэрбум төгрөгийн арилжаа хийх болсон байна(Дүрслэл 5).

Дүрслэл 5: Арилжааны бүтэц /тэрбум төгрөг/  
Арилжаны дүн, Гадаад иргэн+гадаад ААН



Арилжааны дүн, Дотоод иргэн + дотоод ААН




Эх үүсвэр: "ҮЦТХТ" ХХК

**Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас**

Банкуудын ипотекийн зээлийн үлдэгдэл 2016 оны 3 дугаар улирлын байдлаар 3.94 их наяд төгрөгт хүрч, нийт 87,925 хүн орон сууцны зээлд хамрагдсан байна. Үүний 20.3 хувь буюу 798.6 тэрбум төгрөгийг банкууд өөрсдийн эх үүсвэрээр, 77.3 хувь буюу 3 их наяд төгрөгийг ОСИСТТБХ<sup>3</sup>-ийн хүрээнд Монголбанкны санхүүжилтээр, үлдсэн 2.4 хувийг бусад эх үүсвэрээр санхүүжүүлсэн байна (Дүрслэл 6). “МИК”ХХК арилжааны банкуудын ипотекийн зээлээс тодорхой багц сонгон бүрдүүлж, түүнийгээ орон сууцаар баталгаажсан үнэт цаас болгон гаргаж байгаа бөгөөд тэдгээр үнэт цаасны 10 хувийг арилжааны банкууд өөрсдөө, үлдсэн 90 хувийг Монголбанк худалдан авч байна. 2016 оны 3 дугаар улирлын байдлаар “МИК” ХХК нийт 9 удаагийн үнэт цаасжуулалтаар 2.4 их наяд төгрөгийн зээлийг багц болгосон бөгөөд багцын зээлийн үлдэгдэл 2.1 их наяд төгрөгт хүрээд байна.

Дүрслэл 6: Банкуудын ипотекийн зээлийн үлдэгдэл 2016 оны 3 дугаар улирал




Эх үүсвэр: Монголбанк

2016 оны 3 дугаар улиралд шинээр 3,741 байрны зээл олгогдсон бөгөөд үүнээс 23 хувь нь банкуудын эх үүсвэрээр, 77.3 хувь нь ОСИСТТБХ-ын санхүүжилтээр санхүүжигдсэн байна. “МИК”

<sup>3</sup>Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр

ХХК-ийн үнэт цаасжуулсан зээлд нийт 48,805 зээлдэгч байгаа бол банкуудын эх үүсвэрээр санхүүжигдсэн зээлд 20,611 зээлдэгч хамрагдсан байна (Дүрслэл 7).

Дүрслэл 7: Зээлийн санхүүжилтийн эх үүсвэр болон зээлдэгчид



Эх үүсвэр: Монголбанк

### 1.3 Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн арилжаа

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК (ХААБ)-аар дамжуулан нийт 8 төрлийн хөдөө аж ахуйн гаралтай бараа болон түүхий эд арилжаалагддаг. Үүнд: ямааны ноолуур, хонины ноос, тэмээний ноос, завод ноос, бодын хөөвөр, хүнсний буудай болон тосны ургамал зэрэг багтдаг. Завод ноос дотроо адууны, хонины, ямааны, сарлагийн ,тэмээний гэж 5 ангилалд бол бодын хөөвөр нь сарлагийн, адууны, үхрийн гэж 3 ангилалд хуваагддаг.

2016 оны 3 дугаар улирлын байдлаар эдгээр 8 бүтээгдэхүүнээс нийт 5 төрлийн бүтээгдэхүүн арилжаалагдсан. Завод ноосноос зөвхөн ямааны болон сарлагийн завод ноос арилжаалагдаж харин бодын хөөвөрөөс зөвхөн сарлагийн хөөвөр арилжаалагдсан байна (Хүснэгт 7).


Хүснэгт 5: ХААБ-ын 3 дугаар улирлын арилжаа

№	Барааны нэр	Барааныхэмжээ /тонн/	Арилжааны дүн /тэрбум төгрөг/
1	Ямааны ноолуур	6617.70	378.02
2	Хонины ноос	11069.70	18.58
3	Тэмээний ноос	647.10	3.34
4	Бодын хөөвөр		
	Сарлагийн хөөвөр	4.10	0.06
5	Завод ноос		
	Ямааны завод ноос	1043.60	14.95
	Сарлагийн завод ноос	0.11	0.003
<b>Нийт</b>		<b>19382.31</b>	<b>414.95</b>

Эх үүсвэр: Хөдөө аж ахуйн бирж

Тайлант хугацаанд хийгдсэн ХААБ-ийн гүйлгээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.73 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнд: ямааны ноолуур 2.75 хувиар, хонины ноос 38.9 хувиар, тэмээний ноос 63.9 хувиар тус тус өсч, харин завод ноос 24.3 хувиар буурсан бол бодын хөөвөр шинээр 2016 онд арилжаалагдаж эхэлжээ (Дүрслэл 8).

Дүрслэл 8: ХААБ-ийн арилжаа




Эх үүсвэр: Хөдөө аж ахуйн бирж

## II. Даатгалын зах зээл

### 2.1 Даатгалын зах зээлийн хөгжил

Даатгалын гүнзгийрэлт буюу ДНБ-д эзлэх хураамжийн орлогын хувь хэмжээ 2016 оны 3 дугаар улирлын байдлаар 0.51 хувь байна. Хөгжиж буй орнуудын(emerging countries) даатгалын гүнзгийрэлтийн түвшин 2015 онд 2.9 хувь байсан бол манай орны хувьд мөн үед 0.49 хувь байв. Хэдий тийм боловч Монгол Улсын даатгалын гүнзгийрэлтийн түвшин цаашид өсөх хандлагатай байгаа юм (Дүрслэл 11).

Дүрслэл 9. Даатгалын гүнзгийрэлтийн түвшин, тэрбум төгрөг



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

2015 онд хураамжийн орлогын өсөлт хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хувьд аль алинд нь удааширсан үзүүлэлттэй гарав. Дэлхийн урт хугацааны даатгалын хураамжийн орлого 3.3 хувийн(2014 онд 4.7 хувь) өсөлттэй байсан бол ердийн даатгалын хураамжийн орлого 2.5 хувь(2014 онд 2.8 хувь) өсөлттэй байв.

Хөгжингүй орнуудын нийт хураамжийн орлого 2015 онд 2.5 хувиар өсөв. Ердийн даатгалын хураамжийн орлогын өсөлт мэдэгдэхүйц удааширсан ба үүнд эдийн засгийн өсөлт сул байсан нь голчлон нөлөөлөв.

Харин хөгжиж буй орнуудын хураамжийн орлого 9.8 хувийн өсөлттэй гарсан ба хөгжиж буй орнуудын дэлхийн даатгалын зах зээлд эзлэх хувь 1.2 функтээр өсч 18.7 хувь болов. Түүнчлэн хөгжингүй орнуудын 80 орчим хувьд хураамжийн орлогын өсөлт эдийн засгийн өсөлтөөс илүү өндөр байв. (Хүснэгт 8)

Хүснэгт 6. Хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хураамжийн орлогын өсөлтийн хувь (2015/2014)

	Ердийн даатгалын хураамжийн орлогын өсөлт	Урт хугацааны даатгалын хураамжийн орлогын өсөлт	Нийт хураамжийн орлогын өсөлт
Дэлхий	2.5%	3.3%	*
Хөгжингүй орнууд	2.6%	2.5%	2.5%
Хөгжиж буй орнууд	7.8%	12%	9.8%
Монгол	4.6%	14.7%	5.1%

Эх үүсвэр: GIMAR 2015, IAIS

Харин 2015 онд манай орны урт хугацааны даатгалын хураамжийн орлого ердийн даатгалын хураамжийн орлогын өсөлтөөс өндөр буюу 14.7 хувь байсан ба салбарын хувьд хураамжийн орлогын өсөлт(5.1 хувь) эдийн засгийн өсөлтөөс(4.1 хувь) илүү хурдтай байв.

**Сигма 2/2016: Фронтьер зах зээл дэх даатгалын үйл ажиллагаа**

Жижиг эдийн засагтай, орлогын түвшин доогуур, даатгалын салбарын хөгжил эхэн шатандаа яваа хөгжиж буй орнуудыг Фронтьер зах зээл гэж нэрлэдэг. Фронтьер зах зээлд багтах орнуудын бодит ДНБ-ийн жилийн дундаж өсөлт ойрын хугацаанд өндөр (5%-10%) байхаар төсөөлөгдөж байгаа бол даатгалын гүнзгийрэлтийн түвшин доогуур (1.5%-аас доош) үзүүлэлттэй байхаар хүлээгдэж байна. Сигма нь дээрх нөхцөлийг хангах Фронтьер зах зээлүүдийн өсөлтийг үнэлжээ. Зах зээлийн дийлэнх хэсэг Саб-Сахарын Африкийн (ССА) орнууд байсан боловч Тусгаар улсуудын хамтын нөхөрлөл (ТУХН) болон Латин Америк, Азийн орнууд мөн багтжээ.

Даатгалын салбарын Фронтьер зах зээлтэй орнууд хөгжлийн ижил үе шатыг туулж байна. Хөгжлийн эхэн үедээ яваа орнуудын хувьд ердийн даатгал буюу бизнесийн даатгалын өсөлт амьдралын даатгалаас өндөр байдаг. Иргэдийн орлого өсч, хадгалах хандлага нэмэгдэхийн хэрээр амьдралын даатгалын хураамжийн орлого хурдацтайгаар өсдөг байна. Хэдий тийм боловч бүх орны онцлогт нийцсэн нэг хэв маяг байна гэсэн үг биш юм. Тухайлбал Латин Америкт: 1990, 2000-аад онд хийгдсэн институцийн бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор Перу, Колумбын даатгалын салбарын хөгжил Боливи, Эквадор зэрэг орноос илүү байдаг. Эдгээр зах зээл дэх зохицуулалт болон бизнесийн орчин мэдэгдэхүйц сайжирсан бөгөөд гадны даатгагчдын оролцоог дэмжсэн байдаг.

Харин ССА орнуудад зохицуулалт, хяналт шалгалт хангалттай түвшинд хөгжөөгүй байгаа боловч дижитал түгээлтийн суваг бусад хөгжиж буй орнуудаас илүү хөгжсөн байдаг байна. Орлогын түвшин багатай иргэд хүн амын дийлэнх хэсгийг эзэлж буй нь микро даатгал буюу гар утсан дээр суурилсан даатгалын бүтээгдэхүүн хөгжиж, улмаар даатгалын гүнзгийрэлтийн түвшин нэмэгдэх үндэс болжээ. Фронтьер зах зээлийн өсөлтийн бусад шалтгаан нь хөдөө аж ахуйн даатгалын өсөлт болон томоохон дэд бүтцийн төсөл, хөтөлбөрөөр тайлбарлагдаж байгаа юм.

Өмнөд Азийн (Камбож, Лаос, Мьянмар, Вьетнам) Фронтьер зах зээлд, эрх баригчид салбарын хурдацтай хөгжлийг дэмжих даатгалын хууль, эрх зүйн зохицуулалтыг нэвтрүүлэхийг эрмэлзэж байна. Тухайлбал 2013 онд Мьянмарын төрөөс (даатгалын зах зээл 1963 онд бий болсон) хувийн хэвшлийн 12 даатгалын компанид дэмжлэг үзүүлжээ. Түүнчлэн АСЕАН(Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэг)-ийн эдийн засгийн нэгдэл болон Хятадын “Нэг бүс, Нэг зам” бодлогын үр дүнд бий болсон даатгалын салбарын өсөлтийн хувь өндөр байгаа юм.

Фронтьер зах зээл нь урт хугацааны найдвартай байдал шаардах болсон ба даатгагчид зах зээлд хэрхэн нэвтэрч буйг мөн үзүүлжээ. Түүнчлэн орон нутгийн болон олон улсын хамтарсан хөрөнгө оруулалттай даатгалын байгууллагын сул болон давуу тал дээр шинжилгээ хийж, технологийн ашиглалт өндөртэй хүн амтай зах зээлд дижитал түгээлтийн сувгийг нэвтрүүлэхдээ хэрхэн бүтээгдэхүүн үйлчилгээг ойлгоход амар хялбар замаар хүргэх асуудлыг тодотгож өгсөн байна.

*Эх үүсвэр: Сигма репорт, Швед PE*

## 2.2 Даатгалын салбарын бүтэц

Тайлант хугацаанд нийт 3,373 даатгалын компани, зуучлагч, төлөөлөгч, хохирол үнэлэгч, актуарч Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулж байна. 2015 оны жилийн эцсээс мэргэжлийн оролцогчдын тоо 318-аар буурсан.

Хүснэгт 7: Даатгалын салбарын мэргэжлийн оролцогчид


Он	Ердийндаатгал	Урт хугацааны даатгал	Давхар даатгал	Даатгалын төлөөлөгч	Даатгалын зуучлагч	Хохирол үнэлэгч	Нийт
2007	15	-	-	690	2	-	798
2008	15	1	-	1,167	4	-	1,316
2009	17	1	-	1,676	5	2	1,840
2010	16	1	-	2,061	9	6	2,243
2011	16	1	-	2,057	8	9	2,242
2012	17	1	-	2,357	17	9	2,607
2013	16	1	-	3,187	20	14	3,504
2014	16	1	-	3,260	30	20	3,589
2015	15	1	1	3,340	37	27	3,691
2016-III	15	1	1	3,020	40	29	3,373

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Энэ оны 3 дугаар улиралд “Монгол даатгал” ХХК-ийн нийт зах зээлд эзлэх активын хэмжээ өнгөрсөн оноос 2.8 хувиар өсч 22.1 хувьд хүрэв. Түүний араас “Тэнгэр даатгал” ХХК, “Мандал генерал даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК, “Миг даатгал” ХХК нийт хөрөнгийн хэмжээгээрээ тус тус ердийн даатгалын зах зээлийн 7-оос 9.5 хувийг эзэлж байна.

Тайлант хугацаанд дээрх 5 даатгагчид ердийн даатгалын зах зээлийн 51.1 хувийг эзэлж байсан бол уг үзүүлэлт энэ оны мөн үед 3.2 хувиар өсч, 54.3 хувь болов.

Дүрслэл 10: Ердийн даатгалын компаниудын зах зээлд эзлэх хувь




Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Тэдгээрийн 10 байгууллага нийт хөрөнгийн хэмжээгээр зах зээлийн 2.6-аас 6.6 хувийг буюу дунджаар 4.1 хувийг эзэлж байна. Бусад ердийн даатгалын компаниудын хувьд зах зээлд эзлэх хувь хэмжээ ижил түвшинд байгаа юм.

2.3 Даатгалын үйлчилгээний хүртээмж

Даатгалын нягтралын үзүүлэлт буюу нэг хүнд ногдох хураамжийн орлогын харьцаа нь салбарын хүртээмж, эрэлтийг илэрхийлдэг. Хүн амын тоог жилд нэг удаа тооцдог тул даатгалын нягтралыг улирлаар тооцох боломжгүй тул 2015 оны жилийн эцсийн байдлаар үзүүлээ.

Дүрслэл 11: Даатгалын нягтрал (төгрөг)




Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо, ҮСХ  
 2015 оны тайлант хугацаанд нэг хүнд ногдох даатгалын хураамжийн хэмжээ 37,261 төгрөг байсан нь өмнөх оны мөн үеийнхээс 2.7 хувиар өссөн үзүүлэлт юм. Үүнийг даатгалын ангилалаар авч үзвэл, ердийн даатгалын хураамж 36,757 төгрөг, урт хугацааны даатгалын хураамж 541 төгрөг байсан нь урт хугацааны даатгалын хүртээмж хангалтгүй байгааг илэрхийлж байна.

Дүрслэл 12: Даатгалын компани болон зуучлагчдын салбаруудын байршил



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын үйлчилгээний хүртээмжийг илэрхийлэгч өөр нэгэн үзүүлэлт нь даатгалын компанийн салбар, зуучлагчдын тоо юм. Хөдөө орон нутагт нийт 314 компани, зуучлагчдын салбар байгаа бөгөөд нэг аймагт дунджаар 15 ногдож байна.



Дүрслэл 13: Даатгалын компани болон зуучлагчдын салбаруудын байршил

Тайлант хугацаанд Улаанбаатар хотын нийт дүүрэгт даатгалын компани болон зуучлагчийн 195 салбар нэгж бүртгэгдэв. Нийт салбар нэгжүүдийн 80 орчим хувь төвийн 5 дүүрэгт төвлөрсөн байна. Түүнчлэн Солонгос болон Хятад улсад тус тус 1 салбар нэгжүүд үйл ажиллагаа явуулж байна.

## 2.4 Даатгалын салбарын статистик үзүүлэлтүүд

Хүснэгт 8: Салбарын товч мэдээлэл


Үзүүлэлтүүд	Өсөлт хувиар 2016.III/2015.III
Нийт хөрөнгө	22%
Нийт цэвэр ашиг	540%
Хураамжийн орлого	-0.4%
Нөхөн төлбөр	-3%
Давхар даатгалын хураамж	-21%

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

### Нийт хөрөнгө

“Даатгалын компаниудын хөрөнгийн дундаж өсөлт 18 хувьтай байна”

Дүрслэл 14: Нийт хөрөнгө



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо


Нийт хөрөнгө 2015 оны мөн үетэй харьцуулахад 22.3 хувиар буюу 37.8 тэрбум төгрөгөөр өсч 207.4 тэрбум төгрөгт хүрэв. Ердийн даатгал, урт хугацааны даатгал болон хөдөө аж ахуйн давхар даатгалын нийт хөрөнгө харгалзан 21.4 хувь, 9.2 хувь, 30.5 хувиар өсч, тус тус 167 тэрбум, 7.5 тэрбум, 33 тэрбум төгрөг болов (Дүрслэл 16).

Даатгалын 17 компаниудын 8-ынх нь нийт хөрөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20-оос дээш хувиар өссөн байна. Үүнээс “Мандал женерал даатгал” ХХК-ийн нийт хөрөнгийн өсөлт хамгийн өндөр буюу 45.7 хувьтай байна.

### Хураамжийн орлого

Энэ оны 3 дугаар улиралд даатгалын салбарын хураамжийн орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.4 хувиар буурч, 88.8 тэрбум төгрөгт хүрэв. Нийт хураамжийн орлогын 98.9 хувь буюу 87.9 тэрбум төгрөгийг ердийн даатгалын 15 компани бүрдүүлж байгаа бол урт хугацааны даатгал 0.9 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажиллажээ.

Дүрслэл 15: Хураамжийн орлого





Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо


Даатгалын хураамжийн нийт орлогын бүтцэд хөрөнгийн даатгал 30.3 хувь, жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 25.2 хувь, авто тээврийн хэрэгслийн даатгал 12.8 хувь, гэнэтийн осол эмчилгээний зардлын даатгал 10.4 хувийг эзэлж байгаа бөгөөд үлдсэн хэсгийн 19.2 хувийг бусад ердийн даатгалын хэлбэрүүд, 2.1 хувийг урт хугацааны даатгал тус тус эзэлж байна.

*Зуучилсан даатгалын хураамжийн орлого.* Энэ оны 3 дугаар улирлын байдлаар тусгай зөвшөөрөл авсан нийт 40 даатгалын зуучлагч компаниуд үйл ажиллагаагаа явуулж байна. Даатгалын хураамжийн орлогын 17.0 хувийг буюу 15.1 тэрбум төгрөгийг зуучлалын орлого бүрдүүлсэн. Даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулж буй 8 банк энэ улиралд зуучлагдсан хураамжийн орлогын 50 хувийг бүрдүүлжээ.

*Даатгалын төлөөлөгчийн хураамжийн орлого.* Тайлант хугацаанд даатгалын төлөөлөгчид нийт хураамжийн орлогын 42.8 хувь буюу 38.0 тэрбум төгрөгийг бүрдүүлсэн байна.

### Нөхөн төлбөр, давхар даатгалын хураамж

Дүрслэл 16: Нөхөн төлбөр, давхар даатгалын хураамж



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо


Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал 3 дугаар улирлын байдлаар 24.2 тэрбум төгрөгт хүрч, нийт хураамжийн орлогын 27.2 хувийг эзлэв. Ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөрийн зардал нийт нөхөн төлбөрийн зардлын 97.4 хувийг бүрдүүлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нөхөн төлбөрийн зардал 2.9 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа юм.

Тайлант хугацаанд өссөн дүнгээр гадаадын давхар даатгалын компаниудад нийт 26.9 тэрбум төгрөгийг шилжүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 21.3 хувиар буурсан үзүүлэлт юм. Давхар даатгалын хураамжид төлсөн зардал нийт хураамжийн орлогын 30.3 хувийг эзэлж байгаа нь даатгалын салбарын мөнгөн хөрөнгийн гадагшлах урсгал өндөр буйг харуулж байна.

### Цэвэр ашиг

*“2016 оны 3 дугаар улирлын байдлаар даатгалын компаниудын цэвэр ашиг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.4 дахин буюу 9.5 тэрбум төгрөгөөр өсч 11.2 тэрбум төгрөгт хүрэв. Үүнд алдагдалтай ажиллаж байсан байгууллагууд ашигтай ажилласан нь, мөн талаас илүү тооны байгууллагуудын цэвэр ашигийн абсолют өсөлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 500 сая төгрөгөөс дээш дүнтэй байгаа нь нөлөөлөв. “Монгол даатгал” ХХК бусад байгууллагуудаас илүү ашигтай ажиллажээ”*

Дүрслэл 17: Цэвэр ашиг



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо


Дийлэнх даатгалын компаниудын цэвэр ашиг өмнөх оны мөн үеэс 500 сая төгрөгөөс дээш дүнтэйгээр өсөв.

Тухайлбал “Монгол даатгал” ХХК хамгийн өндөр ашигтай ажилласан бөгөөд энэ улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 10.7 дахин их буюу 3.4 тэрбум төгрөгөөр ашиг нь өссөн. Үүнд цэвэр хураамжийн орлого 43 хувиар өсч, нөхөн төлбөр 35 хувиар буурсан нь голлон нөлөөлөв.

2015 оны 3 дугаар улиралд “Монре даатгал” ХХК, “Ард даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК алдагдалтай ажиллаж байсан бол энэ оны мөн үед ашигтай ажиллаж, ашгийн өсөлт нь нийт ердийн даатгалын байгууллагуудын ашгийн өсөлтийн 30 хувийг эзэлж байна. Бусад даатгалын байгууллагуудын хувьд ашгийн өсөлт дунджаар 225.6 сая төгрөг байв. Ашгийн үзүүлэлт ийнхүү өссөн нь даатгалын салбарын цаашдын хөгжилд эерэгээр нөлөөлж, нийт оролцогчдын өрсөлдөх чадвар сайжрах нөхцөл болж байна.

### Нөөц сан

Дүрслэл 18: Нөөц сангийн хэмжээ, өсөлт




Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Энэ оны 3 дугаар улиралд даатгалын салбарын нөөц сангийн хэмжээ(орлогод тооцоогүй хураамжийн нөөцийг нэмж тооцов) өмнөх оны мөн үеэс 27.8 хувиар өсч, 94.4 тэрбум төгрөгт хүрэв. Нөөц сангийн хөрөнгийн дийлэнх хувь нь арилжааны банкуудад хадгаламж болон хадгаламжийн сертификат хэлбэрээр байршиж байна.

**Ашигт ажиллагаа**

Дүрслэл 19: Нийт хөрөнгө, өөрийн хөрөнгийн өгөөж



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо


Салбарын өөрийн хөрөнгийн өгөөж 2010 оны 3 дугаар улиралд хамгийн өндөр буюу 21.5 хувь байсан бол 2014 оны 3 дугаар улиралд уг үзүүлэлт буурч 1.6 хувьд хүрсэн. Гэвч тухайн үеэс өөрийн хөрөнгийн өгөөж эргэн сэргэж эхэлсэн бөгөөд тайлант хугацаанд 11.1 хувьтай байна.

Нийт хөрөнгийн өгөөж дээр мөн өөрийн хөрөнгийн өгөөжтэй адил хандлага ажиглагдаж байна. 2011 оны 3 дугаар улиралд буюу өөрийн хөрөнгийн өгөөжийн хамгийн өндөр түвшнээс 1 үе хойно нийт хөрөнгийн өгөөжийн хамгийн өндөр түвшинтэй үе тохиов. 2014 оны 3 дугаар улиралд мөн нийт хөрөнгийн өгөөж хамгийн доод цэгтээ буюу 0.74 хувьд хүрсэн боловч ирэх онуудад нийт хөрөнгийн ашигт ажиллагаа сэргэж, энэ оны байдлаар 5.5 хувь болов.

2010-аас 2014 онд ийнхүү хөрөнгийн өгөөж буурсан нь цэвэр ашгийн хэмжээ 6 дахин буурсантай холбоотой юм. Харин сүүлийн жилүүдэд даатгалын салбарын цэвэр ашгийн хэмжээ өсч байгаа нь салбарын ажигт ажиллагааны коэффициент өсөх үндэс болж байгаа билээ.

**Хосолсон харьцаа**

Дүрслэл 20: Зардлын харьцаа, хохирол нөхөлтийн харьцаа, хосолсон харьцаа



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Хохирол нөхөлтийн харьцаа<sup>4</sup> нь учирсан хохирлыг орлогод тооцсон хураамжид харьцуулан тооцдог. Тайлант хугацаанд дээрх харьцаа 42.8 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.8 хувиар буурсан үзүүлэлт юм. Харин зардлын харьцаа<sup>5</sup> 47.2 хувьтай байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 17.2 хувиар буурчээ.

Даатгалын салбарын хосолсон харьцаа<sup>6</sup> 2013, 2014, 2015 онуудад харгалзан 103.3 хувь, 105.1 хувь, 111.0 хувь байсан бөгөөд тухайн жилүүдэд үйл ажиллагааны зардлыг даатгалын орлого дангаар

<sup>4</sup>Хохирол нөхөлтийн харьцаа=нөхөн төлбөр/орлогод тооцсон хураамж<sup>5</sup>Зардлын харьцаа=үйл ажиллагааны зардал/ орлогод тооцсон нийт хураамж<sup>6</sup>Хосолсон харьцаа=хохирол нөхөлтийн харьцаа+зардлын харьцаа


нөхөх боломжгүй, даатгалын бус орлогоос нөхөж байсныг илтгэж байна. Тайлант хугацаанд салбарын хэмжээнд хосолсон харьцаа буюу зардлын харьцаа буурч 90.0 хувьтай гарлаа.

### Ш. Хадгаламж, зээлийн хоршоо

#### ХЗХ-дын үйлчилгээний хүртээмж

2016 оны 3 дугаар улирлын байдлаар Хорооноос авсан тусгай зөвшөөрлийн дагуу 276 ХЗХ үйл ажиллагаа явуулж байна. Улаанбаатар хотын хэмжээнд нийт 180, орон нутагт 96 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд нийт 276 ХЗХ 44890 гишүүнтэй. ХЗХ-ны гишүүдийн тоо 2014 оны 3-р улиралтай харьцуулахад өсөх хандлагатай байгаа бол ХЗХ-дын тоо 2015 онд огцом өсч ялангуяа Улаанбаатар хотод 166 ХЗХ болж өнгөрсөн онтой харьцуулахад хоёр дахин нэмэгджээ. Энэ өсөлтөнд нийслэлийн хөтөлбөрийн хүрээнд байгуулагдсан ХЗХ-дын тоо шууд нөлөө үзүүлсэн байна. (Дүрслэл 21).

Дүрслэл 21: ХЗХ-дын тоо, өсөлтийн хувь



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хороо

Дүрслэл 22: Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын байршил




Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Хөдөө орон нутагт 96 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд байршлыг бүсээр авч үзвэл баруун бүсийн аймгуудад хамгийн их буюу 30 ХЗХ ба хангайн бүсэд-28, төвийн бүсэд-25, зүүн бүсэд-13 ХЗХ тус тус үйл ажиллагаа явуулж байна.

### 3.2 ХЗХ-дын салбарын үзүүлэлтүүд

**Нийт хөрөнгө:** Нийт активын хэмжээ 2016 оны 3 дугаар улирлын байдлаар 108.8 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 16.6 хувиар өслөө. (Дүрслэл 24).


Дүрслэл 23: Хадгаламж, зээлийн хоршоодын нийт хөрөнгийн дүн



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хороо

**Зээлийн үзүүлэлт:** ХЗХ-дын нийт зээлийн хэмжээ 3 дугаар улиралд 16 хувиар өсч 84.4 тэрбум төгрөг болсон бол чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.5 функтээр өсч 5 хувьд буюу 4.2 тэрбум төгрөгт хүрлээ. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2009 онд хамгийн өндөр цэгтээ буюу 16.5 хувь хүрч байв. (Дүрслэл 26).

Дүрслэл 24: ХЗХ-дын нийт зээлийн чанар /тэрбум төгрөг/




Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

**Гишүүд болон нийт хадгаламж:** ХЗХ-дын гишүүдийн тоо болон нийт хадгаламж 2007-2016 оны хооронд тогтмол өссөн үзүүлэлттэй байна. Нийт хадгаламж 2016 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 0.9 хувиар өсч 57.6 тэрбум төгрөгт хүрэв.

ХЗХ-дын нийт гишүүдийн тоо 44,890-д хүрч өмнөх оны мөн үеэс 7,072 гишүүнээр нэмэгдсэн байна.


Дүрслэл 25: ХЗХ-дын нийт хадгаламж /тэрбум төгрөг/



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

**Өр, төлбөр ба өөрийн хөрөнгө:** ХЗХ-дын өр төлбөр, өөрийн хөрөнгийн хэмжээ буюу эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15,457,519.4 мянган төгрөгөөр буюу 16.6 хувиар өссөн. Энэ өсөлтөд төсөл хөтөлбөрөөс авсан урт хугацаат зээлийн хэмжээ 4,109,037.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Дүрслэл 26: ХЗХ-дын өөрийн хөрөнгө, өр төлбөр /тэрбум төгрөг/




Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

**ХЗХ-ны үр ашигт байдал:** Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

**ХЗХ-ны үр ашигт байдал:** Тайлант хугацаанд ХЗХ-дын нийт орлого 17.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.9 тэрбум төгрөгөөр өссөн. Нийт зардал 15.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.8 тэрбум төгрөгөөр өссөн бол нийт ашиг 1 тэрбум төгрөгөөр өсч 2.6 тэрбум төгрөгт хүрлээ. Дүрслэл 29-өөс харвал орлого, зарлагын өсөлтийн хурд ижил түвшин байгаа нь ашгийн хэмжээг тогтмол байлгах гол үндэс болж байна.

Дүрслэл 27: ХЗХ-дын ашигт ажиллагаа /тэрбум төгрөг/



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Дүрслэл 28: Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

	Байвал зохих	Үзүүлэлт хангаагүй ХЗХ-дын хувь
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа	5%-аас доошгүй	48.5%
ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА /Нийт хөрөнгийн/	5%-аас их	19.9%

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант хугацаанд салбарын хэмжээнд Хорооноос тогтоосон зайлшгүй хангах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээс ХЗХ-дын 48.5 хувь нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг, 19.9 хувь нь өөрийн хөрөнгийн зохистой харьцааг тус тус хангаж ажиллаагүй байна.




## IV. Банк бус санхүүгийн зах зээл

### 4.1 Эдийн засаг дахь гүнзгийрэлт

ББСБ-уудын эдийн засагт үзүүлж буй нөлөөлөл буюу гүнзгийрэлтийг нийт хөрөнгө болон ДНБ-ийн харьцаагаар тооцоход өмнөх оны мөн үеэс 0.8 функтээр өсч 4.2 хувьд хүрсэн байна. ББСБ-уудын тоо нэмэгдсэн, мөн Хорооноос Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт үйл ажиллагаа эрхлэх ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэх шийдвэр гаргасан нь ББСБ-ын активын хэмжээ нэмэгдэхэд нөлөөлж өмнөх оны мөн үеэс 24.5 хувиар өсч 724.2 тэрбум төгрөгт хүрэв (Дүрслэл 30).

Дүрслэл 29: Нийт хөрөнгө болон ДНБ-ын харьцаа



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

### 4.2 ББСБ-уудын үйлчилгээний хүртээмж

ББСБ-уудын тоог бүс нутгаар ангилахад нийт 509 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаагаас хөдөө, орон нутагт 58, Улаанбаатар хотод 451 байршиж байна. Уг ББСБ-уудын салбар 123 байна.

Дүрслэл 30: ББСБ-ын тоо /бүсээр/




Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

### Үйл ажиллагааны хүртээмжтэй байдал

Улсын дүнгээр 10,000 хүнд ногдох ББСБ-ын тоо 2.07, 100 ААН-д ногдох ББСБ-ын тоо 0.02 байна. Уг дүнг бүс нутгаар ангилан үзвэл Улаанбаатар хотод 10,000 хүн болон 100 аж ахуй нэгжид ногдох ББСБ-ын тоо хамгийн өндөр буюу 3.9, 1.2, харин баруун бүсэд хамгийн бага буюу 0.2, 0.1 байна.



Дүрслэл 31: ББСБ-ын байршил




Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

ББСБ-ын харилцагчиддаа үзүүлж буй 10 төрлийн үйлчилгээнээс зээл санхүүжилт болон валютын арилжаа хамгийн өндөр хувьтай байна. ББСБ-ууд нийт хөрөнгийнхөө 62 хувийг зээл хэлбэрээр олгосон тул зээлдэгчдийн тоог бүс нутаг болон Улаанбаатар хотын дүүргүүдээр тооцлоо.

Ийнхүү тооцоход 2016 оны 3 дугаар улиралд ББСБ-д зээлийн өрийн үлдэгдэлтэй 64,278 харилцагчийн 92.6 хувь нь Улаанбаатар хотод, 7.4 хувь нь хөдөө, орон нутгийн харилцагчид байна.


Дүрслэл 32. Зээлдэгчдийн тоо /бүсээр/



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Орон нутаг дахь нийт зээлдэгчдийг бүсчлэлээр ангилбал төвийн бүсэд 48.1, баруун бүсэд 19.2, зүүн бүсэд 16.7, хангайн бүсэд 16.0 хувь байна.

Дүрслэл 33. Зээлдэгчдийн тоо /дүүргээр/



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо


Улаанбаатар хотын ББСБ-ын зээлдэгчдийн 99.4 хувь нь төвийн 6 дүүрэгт, 0.6 хувь нь Налайх, Багануур дүүрэгт байна. Багахангай дүүрэгт ББСБ үйл ажиллагаа явуулдаггүй. Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт нийт ББСБ-ын 87.4 хувь нь байршиж байна.

Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах тусгай зөвшөөрлийг 2 ББСБ авсан бөгөөд үүнээс “Мобифинанс” ББСБ идэвхтэй үйл ажиллагаа явуулж, цахим мөнгөний 333,035 харилцагчтай болжээ.

### 4.3 ББСБ-уудын тогтвортой байдал

2016 оны 3 дугаар улиралд нийт зээлийн өрийн үлдэгдэл 447.7 тэрбум төгрөг байгаа нь нийт хөрөнгийн 61.8 хувийг эзэлж байна. Харин нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ 56.2 тэрбум төгрөг буюу 12.5 хувь байна.

Дүрслэл 34. Чанаргүй зээлийн хувь




Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант улиралд зээлийн өрийн үлдэгдэлтэй 428 ББСБ байгаа бөгөөд үүнээс чанаргүй зээлийн үлдэгдэлтэй 224 ББСБ байна. Үүнээс чанаргүй зээлийн хувь нь 10 хүртэлх хувьтай 108 ББСБ, 10 хувиас 50 хүртэлх хувьтай 92, 50 хувиас 100 хүртэлх хувьтай 24 ББСБ байна.

ББСБ-уудын эрсдэл даах чадварыг чанаргүй зээл болон 1 дүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаагаар тооцсон бөгөөд уг харьцаа бага байх нь эрсдэл даах чадвар өндөртэйг илэрхийлнэ.

2016 оны 3 дугаар улирлын байдлаар нийт ББСБ-ын 160 буюу 83 хувийнх нь чанаргүй зээл болон 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа 20 хувиас бага ба эрсдэл даах чадвар өндөртэй, 14 буюу 6.3 хувь нь 20.1 хувиас өндөр байгаа бөгөөд эрсдэл даах чадвар муу байна.

Дүрслэл 35. ББСБ-ын эрсдэл даах чадвар




## 4.4 ББСБ-ын салбарын үзүүлэлтүүд

## Зах зээлд эзлэх хувь

ББСБ-уудын зах зээлд эзлэх хувийг нийт хөрөнгө болон орлогоор тооцож зах зээл дэх өрсөлдөөний хэлбэрийг тодорхойллоо. Зах зээл дэх хамгийн их хувийг эзэлж буй 20 компани нийт зах зээлийн 80 хувиас дээш хувийг эзэлж байвал уг зах зээлийг монопол зах зээл гэж үздэг.

Дүрслэл 36. ББСБ-уудын зах зээлд эзлэх хувь



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Банк бус санхүүгийн байгууллагуудын зах зээлд хамгийн өндөр хувийг эзэлж байгаа 20 ББСБ нийт зах зээлийн 41.0 хувийг эзэлж байгаа нь өрсөлдөөнт зах зээлийг илэрхийлж байна. Учир нь зах зээлийн хамгийн ихийг эзэлж буй 3 ББСБ нь ердөө нийт зах зээлийн 3 хувьд үйл ажиллагаа эрхэлжээ. Мөн эдийн засгийн өсөлт удааширч, арилжааны банкууд зээл олгох шаардлага нэмэгдүүлсэнтэй холбоотой санхүүжилтийн эрэлтийг хангахаар ББСБ-уудын тусгай зөвшөөрөл авах хүсэлт өндөр байна.

## Үйл ажиллагааны ангилал


ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг байршлаас нь хамаарч орон нутаг ба нийслэл, үйл ажиллагаагаар нь зээл санхүүжилтийн, валют арилжааны, хөрөнгө удирдлагын гэж ялгаатай тогтоосон. Үүнээс хөрөнгө удирдлагын ББСБ нь итгэлцлийн үйлчилгээгээр бусдын хөрөнгийг удирдах боломжтой ба 2016 оны 3 дугаар улирлын байдлаар 49 ББСБ 287.6 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа нь салбар дахь нийт хөрөнгийн 39.7 хувийг, харин зээл санхүүжилтийн 405 ББСБ 419.5 тэрбум төгрөгийн буюу 57.9 хувь, харин валютын арилжааг дангаар нь эрхэлж буй 54 ББСБ 16.2 тэрбум төгрөгийн буюу 2.2 хувийн хөрөнгөтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Хөрөнгө удирдлагын ББСБ нь өр төлбөрөөр 125.0 тэрбум төгрөг төвлөрүүлсэн ба нийт эх үүсвэрийн 43.5 хувийг, үүний дотор итгэлцлийн үйлчилгээний өр төлбөр 28.4 тэрбум төгрөгийг эзэлж байна. Зээл санхүүжилтийн ББСБ-ийн өр төлбөр 64.5 тэрбум төгрөг буюу 15.4 хувьтай, мөн валют арилжааны ББСБ-ын нийт өр төлбөр 3.6 тэрбум төгрөг буюу 22.1 хувьтай байна.

**Ашигт ажиллагаа**

ББСБ-ын салбарын нийт хөрөнгийн өгөөжийн дундаж<sup>7</sup> 5 хувь, хамгийн их нь 43.9 хувь, хамгийн бага нь сөрөг 53.7 хувь байна. Тайлант улирлын өссөн дүнгээр нийт ББСБ-ын 52.7 хувь буюу 268 нь 1 хувиас 10 хувийн өгөөжтэй ажиллажээ.


Дүрслэл 37. Нийт хөрөнгийн өгөөж



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Өөрийн хөрөнгийн өгөөжийн дундаж 5.5 хувь, хамгийн их нь 82.4 хувь, хамгийн бага нь сөрөг 257.7 хувь байна. Тайлант улирлын өссөн дүнгээр нийт ББСБ-ын 49.5 хувь буюу 252 нь 1 хувиас 10 хувийн өгөөжтэй ажиллажээ.

Дүрслэл 38. Өөрийн хөрөнгийн өгөөж



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

## V. Банкнаас бусад санхүүгийн зах зээлийн хураангуй тойм

Банкнаас бусад санхүүгийн зах зээлийн хөгжил манай оронд сул байна. Тухайлбал, хөрөнгийн зах зээлийн ДНБ-д эзлэх хувь хөгжиж буй орнуудад 30 гаруй хувьтай байхад Монгол Улсад ДНБ-ын 5 хувь байгаа нь хөрөнгийн зах зээлийн цар хүрээ муу байгааг харуулж байна. Даатгалын салбарын гүнзгийрэлт хөгжиж буй орнуудад 2.9 хувь байгаа бол манай оронд 0.49 хувь, бичил санхүүгийн зах зээлийн гүнзгийрэлт ДНБ-ын 3 хүрэхгүй хувьтай байна.

Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс 2020 он гэхэд Хөрөнгийн зах зээлийн ДНБ-д эзлэх хувийг 15 болгох зорилт тавиад байгаа. Гэтэл гадаадын иргэн, ААН-үүдийн арилжааны дүн 2012 оны 3-р улирлаас хойш эрс муудаж, нэг улиралд хийгдэж буй дундаж арилжаа 1.8 тэрбум

<sup>7</sup> Салбарын хэмжээн дэх нийт хөрөнгө болон өөрийн хөрөнгийн өгөөжийг ББСБ бүрийн өгөөжийн дундажаар тооцсон болно.

төгрөг болж буурсан байна. Тиймээс гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд эерэг хүлээлт үүсгэх арга замыг эрэлхийлэх шаардлагатай байна.

2015 оны 4 дүгээр улирлаас хойш буураад байсан дотоодын иргэд, ААН-үүдийн арилжааны дүн сэргэх хандлага ажиглагдаж байна. Эдийн засаг удааширсантай холбоотойгоор хөрөнгө оруулагчид богино хугацаат, эрсдэл багатай санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах сонирхол их байна. Үүнийг ЗГ-ын богино хугацаат үнэт цаасыг худалдан авахаар ирүүлсэн санал, биелсэн хувь харууллаа.

Нийслэлээс алслагдсан бүсэд бичил санхүүгийн хүртээмж сайнгүй байна. ББСБ-ын үйл ажиллагаа Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт төвлөрч, баруун бүсэд хамгийн бага тархжээ. Харин хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагаа баруун бүсэд илүү төвлөрсөн байна. 2016 оны 3 дугаар улирлын байдлаар 276 ХЗХ-доос нийслэл хотод 180, хөдөө орон нутагт 96 нь тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байгаа ба нэг ХЗХ-нд ногдох хүн амын тоо буурч байна. Бүсийн хэмжээнд авч үзвэл, баруун бүс-30, хангайн бүс-28, төвийн бүс-9, говийн бүс-16, зүүн бүс-13 хоршоо тус тус байршиж байна.

Бичил санхүүгийн орчинд чанаргүй зээлийн хувь өсөх хандлагатай байна. ББСБ-ын чанаргүй зээлийн хувь өмнөх улирлаас 0.5 функтээр нэмэгдэж 12.5 хувьд хүрсэн бол ХЗХ-дын чанаргүй зээлийн хувь өмнөх улирлаас 0.2 функтээр өсч 5 хувьд хүрсэн байна.

Даатгалын зах зээлийн нийт хураамжийн орлого, үйл ажиллагааны зардал, нөхөн төлбөрийн зардал 2012 оны 3 дугаар улирлаас эхлэн өсөлтийн хурд огцом саарах хандлага ажиглагдаж байна. 2016 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үетэй харьцуулахад үйл ажиллагааны зардал бусад үзүүлэлтүүдээс илүү хурдтай саарч, 22 хувиар буурсан нь ашигт ажиллагааны үзүүлэлтүүд өндөр дүнтэй гарах нөхцөл бүрдүүлэв.